



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 1/167

Арвайхээр сум

«Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн аймгийн орон тооны бус салбар зөвлөл байгуулах, ажиллах журам батлах тухай»

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл байгуулах тухай” А/590 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/760 дугаар тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө /2021-2024 он-/ний бодлогын хэрэгжилтийг орон нутагт хангах чиг үүрэг бүхий “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн аймгийн орон тооны бус зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, зөвлөлийн ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйгээр удирдан чиглүүлж, захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг салбар зөвлөлийн Орлогч дарга (Д.Шивааннүрдэв)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0304

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны дугаар  
сарын ...-ны өдрийн дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

**“ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
АЙМГИЙН ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛ”-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Салбар зөвлөлийн дарга: Аймгийн Засаг дарга
- Салбар зөвлөлийн орлогч дарга: Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Салбар зөвлөлийн гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
- Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
- Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга
- Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
- Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
- Статистикийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга,
- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн Эх барих, эмэгтэйчүүдийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн Хүүхдийн тусlamж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын хэвлэл  
мэдээллийн ажилтан

Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн  
Өвөрхангай аймаг дахь салбарын тэргүүн

Салбар зөвлөлийн нарийн  
бичгийн дарга:

Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл  
мэндийн хэлтсийн Нөхөн үржихүйн эрүүл  
мэндийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн



-оОо-

Аймгийн Засаг даргын 2023 оны дугаар  
сарын 2-ны өдрийн дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

**ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
АЙМГИЙН ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
АЖИЛЛАХ ЖУРАМ**

**НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмын зорилго нь эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийн (цаашид Зөвлөл гэх) зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа болон түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Салбар зөвлөл нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө болон бусад тушаал, шийдвэр, дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

**ХОЁР. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН,  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

2.1. Салбар зөвлөл нь зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Сумдад орон тооны бус салбар зөвлөл байгуулна. Сумдын салбар зөвлөлүүд нь бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дүрмийг энэхүү журамд нийцүүлэн боловсруулж, орон нутгийн удирдлагын шийдвэрээр баталж, мөрдүүлнэ.

2.3. Эрүүл мэндийн байгууллагаас гадна салбар дундын оролцоог хангаж, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангаж ажиллах ба ажлаа тухай шатны Засаг даргын өмнө тайлагнана.

2.4. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг салбар зөвлөлийн дарга удирдах бөгөөд жилд 2-оос доошгүй удаа хуралдана.

2.5. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг салбар зөвлөлийн дарга эсхүл, салбар зөвлөлийн гишүүдийн олонхийн санаачилгаар зарлан хуралдуулж болно. Гишүүдийн 50-иас дээш хувь нь ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

2.6. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.7. Хуралдааны дэгийг энэ журамд нийцүүлэн салбар зөвлөлийн дарга тогтооно.

2.8. Хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, салбар зөвлөлийн дарга хянан, гарын үсэг зурснаар баталгаажна.

2.9. Хуралдаанаас дүгнэлт, санал, зөвлөмж гарган, холбогдох харьяа

байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

## ГУРАВ. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

### 3.1. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд:

3.1.1.“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах

3.1.2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлыг аймаг, орон нутгийн удирдлагад тухай бүрд нь танилцуулж, шийдвэрлүүлэх

3.1.3. Эх, хүүхэд, өсвөр үе, цэргийн насыны залуучууд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлыг уялдуулах, салбар дундын зохицуулалтыг хангах

3.1.4.“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” чиглэлээр эх, хүүхэд, нөхөн үржихүйн насыны хүн амд ээлтэй байгууллага, иргэнийг шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

3.1.5. Эх, хүүхэд, цэргийн насыны залуучууд, нөхөн үржихүйн насыны хүн амын эрүүл мэндэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн, аймаг, орон нутгийн түвшинд болон Эрүүл мэндийн сайдад уламжлан шийдвэрлүүлэх

3.1.6. Эх, хүүхэд, цэргийн насыны залуучууд, нөхөн үржихүйн насыны хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үндсэн үзүүлэлтийг хэлэлцэн, дүгнэлт хийж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн, үр дүнг тооцох

### 3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах хүрээнд:

3.2.1.“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн биелэлтийг жил бүр үнэлж, үнэлгээнд үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх

3.2.2. Эх, хүүхэд, цэргийн насыны залуучууд, нөхөн үржихүйн насыны хүн амд үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгаа эрүүл мэндийн байгууллагад холбогдох албан тушаалтан, нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан зөвлөн туслах багийг ажиллуулж, аргачилсан зөвлөмжөөр ханган, үр дүнг тооцох

3.2.3. Эх, хүүхдийн эндэгдэл, ноцтой хүндрэл бүртгэгдсэн тохиолдол бүрийн шалтгаан, нөхцлийг хэлэлцэн, давтан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх

**ДӨРӨВ. ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
АЙМГИЙН ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ**

4.1 Салбар зөвлөлийн дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1.Үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлж, нэгтгэн зохион байгуулах, зохицуулах Хуралдааныг зарлах, хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоон хөтөлбөрийг баталж, хуралдааныг даргалан холбогдох асуудлыг хэлэлцүүлэх

4.1.2.“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар Засаг даргын зөвлөл болон холбогдох дээдт шатны байгууллагад тайлاغнах, өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах

4.1.3.Гишүүдийн ажил, чиг үүргийн биелэлтийг дүгнэж, урамшуулах, шаардлага тавих асуудлыг харьяалах байгууллага, албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлэх

4.2.Салбар зөвлөлийн орлогч дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.2.1.Даргын эзгүйд түүний даалгаснаар салбар зөвлөлийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж, нэгтгэн зохион байгуулах, зохицуулах

4.2.2.Хуралдааныг даргалан, холбогдох асуудлыг хэлэлцүүлэх

4.2.3.“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг эрүүл мэндийн салбарын хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, биелэлтийг зөвлөлийн дарга болон Эрүүл мэндийн яаманд тайлагнах

4.3.Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.1.Салбар зөвлөлийн бүхий л эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар даргыг мэдээллээр хангаж ажиллах,

4.3.2.Гишүүдийг шаардлагатай тохиолдолд “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн чиглэлээрх холбогдох мэдээ, мэдээллээр хангах

4.3.3.Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, салбар зөвлөлийн даргаар батлуулах, гишүүдэд ажлын 5 өдрийн өмнө урьдчилан мэдэгдэх

4.3.4.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд гишүүдээс санал авч, нэгтгэн боловсруулж батлуулах

4.3.5.Төлөвлөгөөний биелэлтийг хагас жил тутам тооцож, салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулан, хэрэгжилтийг хангах ажлыг гишүүдийн хамт зохион байгуулах

4.3.6.Хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны шийдвэр, тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх

4.3.7.Хуралдааны тэмдэглэл болон холбогдох тайлан, мэдээллээр архивын нэгж бүрдүүлэн, хуульд заасан хугацаанд байгууллагын архивт хүлээлгэн өгөх

**4.4. Зөвлөлийн гишүүд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.**

4.4.1. Зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд чиг үүргийн дагуу санал боловсруулж оруулах ба хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлгнах

4.4.2. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндэд зарцуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ухуулга, нөлөөллийн ажил зохион байгуулах

4.4.3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн арга хэмжээний төлөвлөгөөг бусад арга хэмжээний төлөвлөгөөнүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх

4.4.1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд"-ийн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх

4.4.2. Салбар зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар санал гарган, хуралдаанаар хэлэлцүүлэх

4.4.3. Хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд биечлэн оролцох

**ТАВ. ЗӨВЛӨЛИЙН САНХҮҮЖИЛТ**

5.1. Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн болон зохион байгуулалтын зардлыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг эрүүл мэндийн газар хариуцна.

5.2. Гишүүд хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг өөрийн харьяалах байгууллагын төсөвт тусган санхүүжүүлнэ.

-оОо-



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 1/167

Арвайхээр сум

«Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн аймгийн орон тооны бус салбар зөвлөл байгуулах, ажиллах журам батлах тухай»

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл байгуулах тухай” А/590 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/760 дугаар тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө /2021-2024 он-/ний бодлогын хэрэгжилтийг орон нутагт хангах чиг үүрэг бүхий “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн аймгийн орон тооны бус зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, зөвлөлийн ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйгээр удирдан чиглүүлж, захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг салбар зөвлөлийн Орлогч дарга (Д.Шивааннүрдэв)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0304

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны дугаар  
сарын ...-ны өдрийн дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

**“ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
АЙМГИЙН ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛ”-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Салбар зөвлөлийн дарга: Аймгийн Засаг дарга
- Салбар зөвлөлийн орлогч дарга: Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Салбар зөвлөлийн гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
- Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
- Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга
- Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
- Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
- Статистикийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга,
- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн Эх барих, эмэгтэйчүүдийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн Хүүхдийн тусlamж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын хэвлэл  
мэдээллийн ажилтан

Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн  
Өвөрхангай аймаг дахь салбарын тэргүүн

Салбар зөвлөлийн нарийн  
бичгийн дарга:

Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл  
мэндийн хэлтсийн Нөхөн үржихүйн эрүүл  
мэндийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн



-оОо-

Аймгийн Засаг даргын 2023 оны дугаар  
сарын 2-ны өдрийн дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

**ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
АЙМГИЙН ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
АЖИЛЛАХ ЖУРАМ**

**НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмын зорилго нь эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийн (цаашид Зөвлөл гэх) зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа болон түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Салбар зөвлөл нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө болон бусад тушаал, шийдвэр, дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

**ХОЁР. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН,  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

2.1. Салбар зөвлөл нь зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Сумдад орон тооны бус салбар зөвлөл байгуулна. Сумдын салбар зөвлөлүүд нь бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дүрмийг энэхүү журамд нийцүүлэн боловсруулж, орон нутгийн удирдлагын шийдвэрээр баталж, мөрдүүлнэ.

2.3. Эрүүл мэндийн байгууллагаас гадна салбар дундын оролцоог хангаж, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангаж ажиллах ба ажлаа тухай шатны Засаг даргын өмнө тайлагнана.

2.4. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг салбар зөвлөлийн дарга удирдах бөгөөд жилд 2-оос доошгүй удаа хуралдана.

2.5. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг салбар зөвлөлийн дарга эсхүл, салбар зөвлөлийн гишүүдийн олонхийн санаачилгаар зарлан хуралдуулж болно. Гишүүдийн 50-иас дээш хувь нь ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

2.6. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.7. Хуралдааны дэгийг энэ журамд нийцүүлэн салбар зөвлөлийн дарга тогтооно.

2.8. Хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, салбар зөвлөлийн дарга хянан, гарын үсэг зурснаар баталгаажна.

2.9. Хуралдаанаас дүгнэлт, санал, зөвлөмж гарган, холбогдох харьяа

байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

## **ГУРАВ. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ**

### **3.1. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд:**

3.1.1.“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах

3.1.2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлыг аймаг, орон нутгийн удирдлагад тухай бүрд нь танилцуулж, шийдвэрлүүлэх

3.1.3. Эх, хүүхэд, өсвөр үе, цэргийн насны залуучууд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлыг уялдуулах, салбар дундын зохицуулалтыг хангах

3.1.4.“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” чиглэлээр эх, хүүхэд, нөхөн үржихүйн насны хүн амд ээлтэй байгууллага, иргэнийг шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

3.1.5. Эх, хүүхэд, цэргийн насны залуучууд, нөхөн үржихүйн насны хүн амын эрүүл мэндэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн, аймаг, орон нутгийн түвшинд болон Эрүүл мэндийн сайдад уламжлан шийдвэрлүүлэх

3.1.6. Эх, хүүхэд, цэргийн насны залуучууд, нөхөн үржихүйн насны хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үндсэн үзүүлэлтийг хэлэлцэн, дүгнэлт хийж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн, үр дүнг тооцох

### **3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах хүрээнд:**

3.2.1.“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн биелэлтийг жил бүр үнэлж, үнэлгээнд үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх

3.2.2. Эх, хүүхэд, цэргийн насны залуучууд, нөхөн үржихүйн насны хүн амд үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгаа эрүүл мэндийн байгууллагад холбогдох албан тушаалтан, нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан зөвлөн туслах багийг ажиллуулж, аргачилсан зөвлөмжөөр ханган, үр дүнг тооцох

3.2.3. Эх, хүүхдийн эндэгдэл, ноцтой хүндрэл бүртгэгдсэн тохиолдол бурийн шалтгаан, нөхцлийг хэлэлцэн, давтан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх

**ДӨРӨВ. ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
АЙМГИЙН ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ**

4.1 Салбар зөвлөлийн дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1.Үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлж, нэгтгэн зохион байгуулах, зохицуулах Хуралдааныг зарлах, хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоон хөтөлбөрийг баталж, хуралдааныг даргалан холбогдох асуудлыг хэлэлцүүлэх

4.1.2.“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар Засаг даргын зөвлөл болон холбогдох дээдт шатны байгууллагад тайлاغнах, өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах

4.1.3.Гишүүдийн ажил, чиг үүргийн биелэлтийг дүгнэж, урамшуулах, шаардлага тавих асуудлыг харьяалах байгууллага, албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлэх

4.2.Салбар зөвлөлийн орлогч дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.2.1.Даргын эзгүйд түүний даалгаснаар салбар зөвлөлийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж, нэгтгэн зохион байгуулах, зохицуулах

4.2.2.Хуралдааныг даргалан, холбогдох асуудлыг хэлэлцүүлэх

4.2.3.“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг эрүүл мэндийн салбарын хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, биелэлтийг зөвлөлийн дарга болон Эрүүл мэндийн яаманд тайлагнах

4.3.Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.1.Салбар зөвлөлийн бүхий л эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар даргыг мэдээллээр хангаж ажиллах,

4.3.2.Гишүүдийг шаардлагатай тохиолдолд “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн чиглэлээрх холбогдох мэдээ, мэдээллээр хангах

4.3.3.Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, салбар зөвлөлийн даргаар батлуулах, гишүүдэд ажлын 5 өдрийн өмнө урьдчилан мэдэгдэх

4.3.4.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд гишүүдээс санал авч, нэгтгэн боловсруулж батлуулах

4.3.5.Төлөвлөгөөний биелэлтийг хагас жил тутам тооцож, салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулан, хэрэгжилтийг хангах ажлыг гишүүдийн хамт зохион байгуулах

4.3.6.Хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны шийдвэр, тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх

4.3.7.Хуралдааны тэмдэглэл болон холбогдох тайлан, мэдээллээр архивын нэгж бүрдүүлэн, хуульд заасан хугацаанд байгууллагын архивт хүлээлгэн өгөх

**4.4. Зөвлөлийн гишүүд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.**

4.4.1. Зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд чиг үүргийн дагуу санал боловсруулж оруулах ба хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлагнах

4.4.2. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндэд зарцуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ухуулга, нөлөөллийн ажил зохион байгуулах

4.4.3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн арга хэмжээний төлөвлөгөөг бусад арга хэмжээний төлөвлөгөөнүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх

4.4.1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд"-ийн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх

4.4.2. Салбар зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар санал гарган, хуралдаанаар хэлэлцүүлэх

4.4.3. Хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд биечлэн оролцох

**ТАВ. ЗӨВЛӨЛИЙН САНХҮҮЖИЛТ**

5.1. Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн болон зохион байгуулалтын зардлыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг эрүүл мэндийн газар хариуцна.

5.2. Гишүүд хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг өөрийн харьяалах байгууллагын төсөвт тусган санхүүжүүлнэ.

-оОо-